



MAGIC
CONSULTING AUDIT

АУДИТ
БАТАЛГААЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭ

**ХӨСӨГ ТРЕЙД ХХК-ИЙН
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР
ТАСАЛБАР БОЛГОСОН ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**АУДИТОРЫН
ТАЙЛАН**

АГУУЛГА	ХУУДАС
БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	1
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3-4
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	5
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	6
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	8
Тодруулга 1 Компанийн зохион байгуулалт ба үйл ажиллагаа	9
Тодруулга 2 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10
Тодруулга 3 Дансны авлага	10
Тодруулга 4 Бусад авлага	10
Тодруулга 5 Бараа материал	10
Тодруулга 6 Урьдчилж төлсөн зардал/тооцоо	10
Тодруулга 7 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	10
Тодруулга 8 Үндсэн хөрөнгө	11
Тодруулга 9 Биет бус хөрөнгө	11
Тодруулга 10 Дансны өглөг	11
Тодруулга 11 Татварын өр	11
Тодруулга 12 Хойшлогдсон татварын өр	12
Тодруулга 13 Бусад урт хугацаат өр төлбөр	12
Тодруулга 14 Хувийн өмч	12
Тодруулга 15 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12
Тодруулга 16 Эздийн өмч бусад хэсэг	12
Тодруулга 17 Хуримтлагдсан ашиг	12
Тодруулга 18 Борлуулалтын орлого (цэвэр)	13
Тодруулга 19 Борлуулалтын өртөг	13
Тодруулга 20 Хүүний орлого	13
Тодруулга 21 Бусад орлого	13
Тодруулга 22 Ерөнхий ба удирдлагын зардал	13
Тодруулга 23 Орлогын татварын зардал	14
Тодруулга 24 Холбоотой талуудын тодруулга	14
Тодруулга 25 Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага	14
Тодруулга 26 Дараагийн аудитаар авч үзэх чухал асуудлууд	15
Тодруулга 27 Балансын дараах үйл явдал	15

БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛУЛСЫН БҮРТГЭЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ

Компани нь 1991 оны 12 сарын 14-ний өдөр анх үүсгэн байгуулагдсан ба 2007 оны 05 сарын 24-ний өдөр УБЕГ-аас олгосон 2037467 тоот регистрийн дугаар бүхий 9010001052 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг эзэмшдэг.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 29,579,300.00 төгрөг бөгөөд дараах гишүүд хувь эзэмшиж байна.

- | | |
|-----------------------|--------|
| 1. Эй Ди Эм Эм Ди ХХК | 32.58% |
| 2. Д.Бадам | 29.79% |
| 3. Г.Маргад | 18.23% |
| 4. С.Жавзан-Орлом | 17.57% |
| 5. Бусад | 1.83% |

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.Эрдэнэсүх

ХАРИЛЦАГЧ БАНК

Худалдаа хөгжлийн банк

АЛБАН ХАЯГ

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Дунд гол өөрийн байр

АУДИТОР

Мэжик Консалтинг Аудит ХХК
Мэргэшсэн Нягтлан Бодогчид
Юу Би тауэр, 15 давхар, 1502 тоот
Баянзүрх дүүрэг, 43-р хороо,
Улаанбаатар хот, Монгол

**2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн
санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү мэдэгдэл нь Хөсөг Трейд ХК-ийн (Цаашид 'Компани' гэх) 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгахад чиглэгдсэн болно.

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС"), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан заавар журмын дагуу үнэн зөв, шударгаар бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.


ХӨСӨГ ТРЕЙД ХК
KHUSOG TRADE
JSC
М.Эрдэнэсүх
Гүйцэтгэх захирал
2037457 & СБТ11610
УЛААНБААТАР ХОТ


Ерөнхий нягтлан бодогч

Огноо: 2025 оны 03 дугаар сарын 20

Улаанбаатар хот

МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
43-р хороо, Манлай Баатар Дамдинсүрэнгийн
гудамж, UB tower, 15 давхар, 1502 тоот.
Утас: 7288-7288. И-мэйл: info@magicgroup.mn
Вэб хуудас: www.magicgroup.mn

2025-03-20 дугаар 25-UB/04/44

танай _____-ны дугаар _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Дүгнэлт

Бид Хөсөг Трейд ХК ('Компани' гэх)-ийн 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон Санхүүгийн байдлын тайлан, жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар компанийн 2024 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт ('АОУС')-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЭЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Тасралтгүй байдалтай холбоотой материаллаг тодорхойгүй байдал

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд нь тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудал юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Татварын тооцооллын үнэн зөв байдал

Татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн. Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монгол улсын Засгийн газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээсэн үүрэг хариуцлагын тодорхойлолтыг Мэжик Консалтинг Аудит ХХК-ийн <http://www.magicgroup.mn/mn/uureg> вэб сайтад байршуулсан. Уг тодорхойлолт нь аудиторын тайлангийн нэг хэсэг юм.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох Хөсөг Трейд ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Д.ТҮМЭНЖАРГАЛ
АУДИТЫН ПАРТНЕР
МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС

2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

(Төгрөгөөр)

	Тод	2023-12-31	2024-12-31
ХӨРӨНГӨ			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2	6,630,896.92	25,071,029.32
Дансны авлага	3	45,853,295.19	573,492,689.09
Бусад авлага	4	-	712,447.26
Бараа материал	5	1,207,818.18	998,818.18
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6	373,630,556.00	22,000.00
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	7	1,210,218.19	1,210,218.19
		428,532,784.48	601,507,202.04
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	8	445,213,432.23	468,245,677.99
Биет бус хөрөнгө	9	403,805,501.94	623,770,082.73
		849,018,934.17	1,092,015,760.72
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1,277,551,718.65	1,693,522,962.76
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Дансны өглөг	10	139,926,563.59	176,543,043.27
Татварын өр	11	1,873,797.70	80,578,127.73
		141,800,361.29	257,121,171.00
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Хойшлогдсон татварын өр	12	-	512,036.41
Бусад урт хугацаат өр төлбөр	13	359,690,010.49	353,826,580.29
		359,690,010.49	354,338,616.70
ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		501,490,371.78	611,459,787.70
ЭЗДИЙН ӨМЧ:			
Хувийн өмч	14	29,579,300.00	29,579,300.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15	904,000,000.00	904,000,000.00
Эздийн өмч бусад хэсэг	16	6,240,000.00	6,240,000.00
Хуримтлагдсан ашиг	17	(163,757,953.13)	142,243,875.06
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		776,061,346.87	1,082,063,175.06
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		1,277,551,718.65	1,693,522,962.76

Хуудас 9-15-д харуулсан тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

(Төгрөгөөр)

	Тод	2023-12-31	2024-12-31
Борлуулалтын орлого (цэвэр)	18	62,272,727.28	714,008,041.91
Борлуулалтын өртөг	19	-	209,891,843.54
Нийт ашиг		62,272,727.28	504,116,198.37
Хүүний орлого	20	4,307,931.17	174,321.06
Бусад орлого	21	58,029,698.99	4,665,564.14
Ерөнхий ба удирдлагын зардал	22	249,604,164.62	199,693,374.50
Бусад зардал		17,680.70	-
Нийт		311,959,475.48	204,533,259.70
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(125,011,487.88)	309,262,709.07
Орлогын татварын зардал	23	(430,793.13)	(3,260,880.88)
Татварын дараах ашиг (алдагдал)		(125,442,281.01)	306,001,828.19
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг		-	-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/		(125,442,281.01)	306,001,828.19
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Орлогын нийт дүн		(125,442,281.01)	306,001,828.19

Хуудас 9-15-д харуулсан тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

(Төгрөгөөр)

	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмч бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023-12-31	29,579,300.00	904,000,000.00	6,240,000.00	(163,757,953.13)	776,061,346.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-	-
Залруулсан үлдэгдэл	29,579,300.00	904,000,000.00	6,240,000.00	(163,757,953.13)	776,061,346.87
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/				306,001,828.19	306,001,828.19
Бусад дэлгэрэнгүй орлого			-		-
Өмчид гарсан өөрчлөлт	-		-		-
Зарласан ногдол ашиг				-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-		-
2024-12-31	29,579,300.00	904,000,000.00	6,240,000.00	142,243,875.06	1,082,063,175.06

Хуудас 9-15-д харуулсан тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2023-12-31	2024-12-31
1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1 Мөнгөн орлогын дүн (+)	238,328,239.69	302,601,844.99
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	106,079,373.69	216,358,725.33
Бусад мөнгөн орлого	132,248,866.00	86,243,119.66
1.2 Мөнгөн зарлагын дүн (-)	530,456,295.26	284,336,033.65
Ажилчдад төлсөн	271,040.00	-
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	-
Бараа материал худалдан авахад төлсөн	-	22,000.00
Ашиглалтын зардалд төлсөн	77,673,577.75	204,908,693.30
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	2,112.83
Хүүний төлбөрт төлсөн	-	800.00
Татварын байгууллагад төлсөн	448,913,877.08	76,939,765.76
Бусад мөнгөн зарлага	3,597,800.43	2,462,661.76
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(292,128,055.57)	18,265,811.34
2 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1 Мөнгөн орлогын дүн (+)	4,307,931.17	174,321.06
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Хүлээн авсан хүүний орлого	4,307,931.17	174,321.06
2.2 Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,307,931.17	174,321.06
3 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1 Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
.....	-	-
3.2 Мөнгөн зарлагын дүн (-)	460,400.00	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	460,400.00	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(460,400.00)	-
4 Валютын ханшын зөрүү	-	-
4.1 Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(288,280,524.40)	18,440,132.40
5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	294,911,421.32	6,630,896.92
6 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,630,896.92	25,071,029.32

1. Компанийн зохион байгуулалт ба үйл ажиллагаа

Хөсөг Трейд ХК (цаашид "Компани" гэх)-ийг анх 1991 оны 12 сарын 14-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийн дагуу хувьцаат компани хэлбэрээр үүсгэн байгуулсан. 2007 оны 05 сарын 24-ний өдөр Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 2037467 тоот регистр бүхий 9010001052 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авсан.

Компани нь тусгай зөвшөөрөл шаардагддаг үйл ажиллагаа явуулдаггүй.

Компанийн дүрмэнд зааснаар дараах бизнесийн үйл ажиллагааны чиглэлүүдтэй байна.

1. Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа

2024 оны 12 сарын 31-ний байдлаар хүчин төгөлдөр компанийн дүрмийн дагуу голлох хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон хувьцаат капитал нь дараах байдалтай байна. Үүнд:

№	Голлох хувьцаа эзэмшигчид	Эзэмшлийн хувь	2024 оны 12 сарын 31
			Нийт (төгрөг)
1	Эй Ди Эм Эм Ди ХХК	32.58%	9,636,936
2	Дэмчиг Бадам	29.79%	8,811,673
3	Гэрэлчулуун Маргад	18.23%	5,392,306
4	Сандаг Жавзан-Орлом	17.57%	5,197,083
5	Бусад	1.83%	541,301
		100%	29,579,300

Компанид хамгийн дээд хянагч болон толгой компани байхгүй болно.

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж буй аудитын хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа компаниас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно.

Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

2. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	Өөрчлөлт	2023-12-31	(төгрөг) 2024-12-31
2.2 Банкин дахь мөнгө			
Худалдаа хөгжлийн банк /төгрөг/ Дүн	3.78	6,630,896.92	25,071,029.32
	3.78	6,630,896.92	25,071,029.32
Нийт дүн		6,630,896.92	25,071,029.32

3. ДАНСНЫ АВЛАГА

	Өөрчлөлт	2023-12-31	(төгрөг) 2024-12-31
Борлуулалтын авлага	12.51	45,853,295.19	573,492,689.09
	12.51	45,853,295.19	573,492,689.09

2024-12-31-ний байдлаар Дансны авлага 527,639,393.90 төгрөгөөр буюу 12.51 дахин өссөн.
Дансны авлага нь 100 хувь Борлуулалтын авлага данснаас бүрдсэн байна.
Нийт хөрөнгийн 33.86 хувийг Дансны авлага эзэлж байна.

4. БУСАД АВЛАГА

	Өөрчлөлт	2023-12-31	(төгрөг) 2024-12-31
Бусад авлага	-	-	712,447.26
	-	-	712,447.26

5. БАРАА МАТЕРИАЛ

	Өөрчлөлт	2023-12-31	(төгрөг) 2024-12-31
Хангамжын материал	0.83	1,207,818.18	998,818.18
	0.83	1,207,818.18	998,818.18

6. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО

	Өөрчлөлт	2023-12-31	(төгрөг) 2024-12-31
Урьдчилж төлсөн түрээс, даатгал	0.00	373,630,556.00	22,000.00
	-	373,630,556.00	22,000.00

2024-12-31-ний байдлаар Урьдчилж төлсөн зардал/тооцоо 373,608,556.00 төгрөгөөр буюу (99+) дахин буурсан.
Урьдчилж төлсөн зардал нь 100 хувь Урьдчилж төлсөн түрээс, даатгал гэсэн данснаас бүрдсэн байна.

**7. БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БУЙ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ
(БОРЛУУЛАХ БҮЛЭГ ХӨРӨНГӨ)**

	Өөрчлөлт	2023-12-31	(төгрөг) 2024-12-31
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	1.00	1,210,218.19	1,210,218.19
	1.00	1,210,218.19	1,210,218.19

8. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	Өөрчлөлт	2023-12-31	(төгрөг) 2024-12-31
Барилга байгууламж	1.19	757,859,921.86	904,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл. Барилга	1.38	(318,188,286.50)	(440,326,873.65)
Машин, тоног төхөөрөмж	-	57,500,000.00	-
Хуримтлагдсан элэгдэл. МТТ	-	(57,500,000.00)	-
Тээврийн хэрэгсэл	1.00	6,000,000.00	6,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл. Тээвэр	1.29	(2,107,068.67)	(2,708,383.04)
Тавилга эд хогшил	1.00	6,244,272.73	6,244,272.73
Хуримтлагдсан элэгдэл. ТЭХ	1.08	(4,595,407.19)	(4,963,338.05)
Компьютер, бусад хэрэгсэл	-	8,278,827.27	-
Хуримтлагдсан элэгдэл. Компьютер	-	(8,278,827.27)	-
	1.05	445,213,432.23	468,245,677.99

2024-12-31-ний байдлаар үндсэн хөрөнгийн дүн 23,032,245.76 төгрөгөөр буюу 5 хувиар өссөн.

Үндсэн хөрөнгийн хамгийн их буюу 98.66 хувийг Барилга байгууламж эзэлж байна.

Оны эцсийн байдлаар нийт үндсэн хөрөнгийн анхны өртөг 916,244,272.73 төгрөг, хуримтлагдсан элэгдэл -447,998,594.74 төгрөг, үлдэгдэл өртөг 468,245,677.99 төгрөг. 48.90 хувь нь элэгдсэн үзүүлэлттэй байна. Үндсэн хөрөнгө нь Нийт хөрөнгийн 27.65 хувийг эзэлж байна.

9. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	Өөрчлөлт	2023-12-31	(төгрөг) 2024-12-31
Газар эзэмших эрх	1.55	403,362,433.49	623,427,233.35
Бусад биет бус хөрөнгө	1.00	1,000,000.00	1,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл. Бусад биет бус хөрөнгө	1.18	(556,931.55)	(657,150.62)
	1.54	403,805,501.94	623,770,082.73

Нийт хөрөнгийн 36.83 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

2024-12-31-ний байдлаар Биет бус хөрөнгө 219,964,580.79 төгрөгөөр буюу 54 хувиар өссөн.

10. ДАНСНЫ ӨГЛӨГ

	Өөрчлөлт	2023-12-31	(төгрөг) 2024-12-31
Бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг	1.26	139,926,563.59	176,543,043.27
	1.26	139,926,563.59	176,543,043.27

2024-12-31-ний байдлаар Дансны өглөг 36,616,479.68 төгрөгөөр буюу 26 хувиар өссөн.

Дансны өглөг нь 100 хувь Бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг гэсэн данснаас бүрдсэн байна.

Нийт өр төлбөрийн 28.87 хувийг дансны өглөг эзэлж байна.

11. ТАТВАРЫН ӨР

	Өөрчлөлт	2023-12-31	(төгрөг) 2024-12-31
НӨАТ-ын тооцоо	25.69	1,873,797.70	48,143,639.84
Орлогын татварын тооцоо	-	-	32,434,487.89
	43.00	1,873,797.70	80,578,127.73

2024-12-31-ний байдлаар Татварын өр 78,704,330.03 төгрөгөөр буюу 43 дахин өссөн.

Татварын өглөгийн хамгийн их буюу 59.75 хувийг НӨАТ-ын тооцоо эзэлж байна.

Нийт өр төлбөрийн 13.18 хувийг татварын өглөг эзэлж байна.

12. ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ӨР

(төгрөг)

	Өөрчлөлт	2023-12-31	2024-12-31
Хойшлогдсон татварын өр	-	-	512,036.41
	-	-	512,036.41

13. БУСАД УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

(төгрөг)

	Өөрчлөлт	2023-12-31	2024-12-31
Бусад урт хугацаат өр төлбөр	0.98	359,690,010.49	353,826,580.29
	0.98	359,690,010.49	353,826,580.29

буурсан.

Нийт өр төлбөрийн 57.87 хувийг Бусад урт хугацаат өглөг эзэлж байна.

14. ХУВИЙН ӨМЧ

(төгрөг)

	Өөрчлөлт	2023-12-31	2024-12-31
Хувийн өмч	1.00	29,579,300.00	29,579,300.00
	1.00	29,579,300.00	29,579,300.00

15. ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ

(төгрөг)

	Өөрчлөлт	2023-12-31	2024-12-31
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1.00	904,000,000.00	904,000,000.00
	1.00	904,000,000.00	904,000,000.00

Тайлант хугацаанд Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэлд 'мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй'.

16. ЭЗДИЙН ӨМЧ БУСАД ХЭСЭГ

(төгрөг)

	Өөрчлөлт	2023-12-31	2024-12-31
Эздийн өмч бусад хэсэг	1.00	6,240,000.00	6,240,000.00
	1.00	6,240,000.00	6,240,000.00

17. ХУРИМТЛАГДСАН АШИГ

(төгрөг)

	Өөрчлөлт	2023-12-31	2024-12-31
Тайлант үеийн ашиг	-	-	306,001,828.19
Өмнөх үеийн ашиг	1.00	(163,757,953.13)	(163,757,953.13)
	0.87	(163,757,953.13)	142,243,875.06

2024-12-31-ний байдлаар өмнөх үеийн Хуримтлагдсан алдагдал данс 306,001,828.19 төгрөгөөр буурч 142,243,875.06 төгрөгийн Хуримтлагдсан ашиг бий болсон байна. /Эерэг үзүүлэлт/

Хуримтлагдсан ашиг нь нийт эзний өмчийн 13.15 хувийг эзэлж байна.

Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг /алд/ дансанд өөрчлөлт ороогүй байна.

18. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)	Өөрчлөлт	(төгрөг)	
		2023-12-31	2024-12-31
Ажил үйлчилгээ борлуулсны орлого	11.47	62,272,727.28	714,008,041.91
	11.47	62,272,727.28	714,008,041.91

Борлуулалтын орлого (цэвэр) 651,735,314.63 төгрөгөөр буюу 11.47 дахин өссөн.

19. БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ	Өөрчлөлт	(төгрөг)	
		2023-12-31	2024-12-31
Шууд материалын зардал /ТЭМЗ/	-	-	209,891,843.54
	-	-	209,891,843.54

Тайлант хугацааны эцэст Борлуулалтын өртөг 209,891,843.54 төгрөгөөр нэмэгдсэн.
2023 онд Нийт борлуулалтын 0.00 хувь, 2024 оны байдлаар 29.40 хувь нь Борлуулсан бүтээгдэхүүний өртөг байна. Өөрчлөлт 29.40 хувь

20. ХҮҮНИЙ ОРЛОГО	Өөрчлөлт	(төгрөг)	
		2023-12-31	2024-12-31
Хүүний орлого	0.04	4,307,931.17	174,321.06
	0.04	4,307,931.17	174,321.06

21. БУСАД ОРЛОГО	Өөрчлөлт	(төгрөг)	
		2023-12-31	2024-12-31
Бусад орлого	-	58,029,698.99	-
Үйл ажиллагааны бус орлого	-	-	4,665,564.14
	0.08	58,029,698.99	4,665,564.14

Өмнөх онтой харьцуулахад Бусад орлого 53,364,134.85 төгрөгөөр буюу 12.44 дахин буурсан.

22. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ	Өөрчлөлт	(төгрөг)	
		2023-12-31	2024-12-31
Албан татвар, төлбөр, хураамж	0.97	7,541,563.64	7,305,500.00
Бичиг хэргийн зардал	5.83	189,771.63	1,105,481.82
Мэргэжлийн үйлчилгээний зардал	0.26	2,733,127.27	700,000.00
Сонин сэтгүүл захиалгын зардал	-	454,545.46	-
Ашиглалтын зардал	0.01	71,335,082.31	419,810.28
Элэгдэл, хорогдлын зардал	0.96	128,651,750.39	123,208,051.45
Түрээсийн зардал	-	-	66,059,979.80
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	-	545,454.55	-
Тээврийн зардал	-	249,181.82	-
Шатахууны зардал	-	-	181,818.18
Хүлээн авалтын зардал	0.94	263,774.55	246,636.36
Бусад зардал	0.01	37,639,913.00	466,096.61
	0.80	249,604,164.62	199,693,374.50

Өмнөх онтой харьцуулахад Ерөнхий ба удирдлагын зардал 49,910,790.12 төгрөгөөр буюу 20 хувиар буурсан.

23. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

	Өөрчлөлт	2023-12-31	2024-12-31
Тайлангийн үеийн орлогын татварын зардал	7.57	430,793.13	3,260,880.88
	7.57	430,793.13	3,260,880.88

(төгрөг)

24. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

24.1 Холбоотой талуудыг тодорхойлох

Компанийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой хяналт хэрэгжүүлдэг талууд болон түүнтэй шууд хамааралтай талуудыг холбоотой тал гэж үзэх бөгөөд холбоотой талууд нь хувь хүмүүс, аж ахуйн нэгж байгууллагууд байж болно. Холбоотой талуудыг тодорхойлохдоо компаниас гаргаж өгсөн болон нийтэд ил тод байгаа мэдээлэлд суурилсан учраас тодруулагдаагүй бусад холбоотой талууд, ажил гүйлгээ байж болзошгүй.

Компанийн холбоотой талууд болон тэдгээрийн харилцан хамаарлыг харуулбал:

Холбоотой талуудын нэрс-Улс	Оролцоо	Хамаарал	Төрөл
Эй Ди Эм Эм Ди ХХК-Монгол	32.58%	Хувьцаа эзэмшигч	-
Д.Бадам-Монгол	29.79%	Хувьцаа эзэмшигч	-
Г.Маргад-Монгол	18.23%	Хувьцаа эзэмшигч	-
С.Жавзан-Орлом-Монгол	17.57%	Хувьцаа эзэмшигч	-
Бусад-Монгол	1.83%	Хувьцаа эзэмшигч	-
М.Эрдэнэсүх-Монгол		Гүйцэтгэх захирал	-

25. ХҮЛЭЭЖ БОЛЗОШГҮЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа үед байгууллага нь түүний эсрэг нэхэмжлэл хүлээн авч болно. Компанийн удирдлага эдгээр нэхэмжлэлүүдээс үүдэлтэйгээр ирээдүйд материаллаг алдагдалд орж болзошгүй тул шаардлагатай сэргийлэх арга хэмжээг авах нь зүйтэй юм.

Татвар, НДШ, шүүхийн зарга маргаан

Монгол улсын татвар, Нийгмийн даатгал, бусад хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах тохиолдол байдаг. Мөн түүнчлэн төрийн байгууллагууд хууль тогтоомжийг тайлбарлан үнэлэхдээ хатуу байр суурь баримталдаг ба өмнө нь маргалдаж байгаагүй үйл ажиллагаа, ажил гүйлгээг үгүйсгэх боломжтой. Үүний үр дүнд, мэдэгдэхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алдангийг ногдуулах магадлалтай байдаг. Хэдийгээр Компанийн удирдлага бусдын өмнө хүлээсэн болзошгүй үүрэг хариуцлага болон алдагдал учрах үйл явдал тохиолдоогүй гэж үзэж болох боловч төрийн байгууллагуудын байр суурийг урьдчилан таамаглах боломжгүй юм.

Татвар, НДШ, хураамжтай холбоотой болзошгүй өр төлбөр

Компанийн хувьд төлөхөөр хүлээгдэж буй татварын хуримтлагдсан өр төлбөрүүд нь 2024 оны 12 сарын 31-ээр дараах байдалтай байна. Үүнд: НӨАТ-ийн өглөг 48,143,640.00 төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба уг өглөгийг хугацаанд нь төлөөгүйгээс хамаарч ирээдүйд алданги хүлээх эрсдэлтэй байна.

Шүүхийн нэхэмжлэл

2024 оны 12 сарын 31-ээр Хөсөг Трейд ХК-ийн эсрэг гаргасан ямар нэг томоохон зарга маргаан, шийдвэрлэгдээгүй нэхэмжлэл байгаагүй. Өөрөөр хэлбэл, Компанийн ирээдүйн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварт эргэлзээ төрүүлэхүйц болзошгүй өр төлбөрийн эрсдэл байхгүй байна.

26. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ ЧУХАЛ АСУУДЛУУД

Компанид дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

27. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулахыг шаарддаг үйл явдал тайлант хугацаа дуусгавар болсон өдрөөс хойш санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн өдрийг хүртэл гараагүй гэж үзэж байна.

2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр



МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Хэмжиж үл чадвал, Удирдаж үл чадна



7288-7288
8811-2064



www.magicgroup.mn
audit@magicgroup.mn



Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
43-р хороо, UB Tower, 15-р давхарт, 1502 тоот